



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 16 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/76

Баянгол

Мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх
вакцин тарих ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.1, 4.5.6, 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2016 оны А/361 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын мялзан төст өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг тарих ажлыг 2016 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн 10 хоногт багтаан зохион байгуулсугай.
2. Вакцин тарих ажлын хэсгийг баг тус бүрээр нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Вакцин тарих цэг, хугацааг урьдчилан малчдад хүргэж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.
4. Тогтоосон хугацаанд малаа вакцинд хамруулахыг малчдад үүрэг болгосугай
5. Вакциныг технологийн дагуу чанартай тарихыг МЭҮҮН-ийн эмч нарт үүрэг болгосугай.
6. Уг ажилд явцын хяналтыг журмын дагуу хийж, тайланг аймгийн Онцгой байдлын газарт илтгэхийг МЭҮТ-ийн Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч /Б.Гантулга/, ОБГ-ын дэслэгч /Б.Батсуурь/ нарт даалгасугай.
7. Вакцин тарилтыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, өдөр тутмын мэдээг ОБГ-ын 7048105 дугаар утсанд тогтоосон цагт өгч байхыг МЭҮТ-ийн дарга /Х.Даваацэрэн/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/zahiramj/2016

00700161